



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Баян-Агт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2025/017/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2025 он</p>	<p>Даргын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Энцоодол Утас: 99057478 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 99057478 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цэрэнлхам Утас: 99079641 Цахим хаяг: Tserenlkhamg@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.	3
ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
5.1 Төлбөрийн акт	10
5.2 Албан шаардлага.....	10
5.3 Зөвлөмж.....	10
ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
БХС	Байаль хамгаалах сан
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
СЗДТГ	Сумын засаг даргын Тамгын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2025.03.24 № 267
танай _____ ны № _____ т

**БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.БЯМБАЖАВ ТАНАА**

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Булган аймгийн Баян-Агт сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчил, түүний санхүүгийн тайлан, тодруулгад үзүүлэх нөлөөг эс тооцвол Булган аймгийн Баян-Агт сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эх үүсвэрийг 52.4 сая төгрөгөөр баталсан байхад 48.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 27.1 сая төгрөгийн орлогын талбай тусгаарлалт, үнэт цаас, модны нөхөн төлбөрийн орлогыг илүү тайлагнасан,
2. Талбай тусгаарлалтын гэрээнд заасан тусгаарлалтын зардлын дүн, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын дүн, нэгдсэн тайланд тайлагнасан дүнтэй зөрүүтэй тайлагнасан, харилцагчтай үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,
3. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрдүүлэхдээ нөхөрлөл, аж ахуй нэгжүүдийн хийлгэсэн талбай тусгаарлалтын гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн, мод бэлтгэх эрх олгосон,
4. Сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данснаас өвс тэжээлийн орлогыг шийдвэргүйгээр авч, ЖДҮДС-ийн тайланд орлогоор бүртгэж тайлагнасан,

• 632502741

мөн зээлийн эргэн төлөлтийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн,

5. Байгаль хамгаалах сангаас бараа үйлчилгээний бусад зардлаас шатахууны зардалд зарцуулсан, тээвэр шатахууны зардалд горим сорил хэрэгжүүлэхэд анхан шатны баримтын бүрдэл дутуу, шаардах хуудас, зарлагын баримт байхгүй, хяналт шалгалт хийсэн гэх боловч хяналт шалгалтын төлөвлөгөө, удирдамж, хийсэн ажлын тайлан байхгүй, жолоочийн тооцоо бодоогүй, гарын үсгийн бүрдэл дутуу анхан шатны баримтыг санхүүгийн тайланд тусгасан,
6. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих 145 мэдээллээс 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь шилэн дансны тухай хуулийн тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй,
7. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 6 төсвийн шууд захирагч, 5 тусгай сангийн нийт 11 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас хэтэрсэн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Сангийн сайдын "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх" 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам нь 2023 онд хүчингүй болсон боловч, тус яамнаас өгсөн чиглэлийн дагуу хуучин журмыг мөрдөж ажиллах чиглэлийг өгсөн байна.

Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хуулиар олгогдсон бүрэн эрхийн хэтрүүлэн шийдвэр гаргаснаас төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй, үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан зөрчлүүд илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны XVIII дугаар хуралдааны 09 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралтаар 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг батлуулж, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын 2 хөтөлбөрийг 5 шалгуур үзүүлэлт, гүйцэтгэх засаглалын 8 хөтөлбөрийг 11 шалгуур үзүүлэлтээр хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөг)

Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		952,780.40	1,235,713.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	381,432.20	749,639.40
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	354,584.60	268,143.90
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	216,763.50	217,929.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,996,552.60	4,089,571.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,996,552.60	4,089,571.40
39200	Биет хөрөнгө		2,948,271.60	4,041,327.90
39300	Биет бус хөрөнгө	13	48,281.00	48,243.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		3,949,333.00	5,325,284.40
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		271.8	1,896.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	271.8	1,896.50
41300	Өглөг	17а, 17б	271.8	1,896.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,949,061.20	5,323,387.80
51	Засгийн газрын хувь оролцоо		3,949,061.20	5,323,387.80
51100	Засгийн газрын оруулсан капитал		300,275.90	300,275.90
51200	Хуримтлагдсан үр дүн		3,460,907.50	4,835,234.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		187,877.80	187,877.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		3,949,333.00	5,325,284.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөг)

Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		4,035,418.40	5,271,404.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО		445,595.20	724,424.20
110	Орлогын албан татвар		288,527.20	553,120.20
1100	Хувь хүний орлогын албан татвар		288,527.20	553,120.20
113	Хөрөнгийн албан татвар		82,936.40	93,924.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж		74,131.70	77,379.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	788,184.00	1,131,469.60
120	Нийтлэг татварын бус орлого		788,184.00	1,131,469.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,801,639.20	3,415,510.60
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,846,479.60	4,031,517.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,846,479.60	3,720,720.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,358,577.10	1,760,995.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		485,353.60	735,596.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		61,952.00	92,197.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		50,024.10	52,211.20
2104	Хангамж, бараа материалын зардал		38,263.40	76,657.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		28,233.00	10,120.70
2107	Томилолт, зочны зардал		5,954.50	22,884.40

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,822.80	8,225.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	669,973.80	763,102.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,487,902.50	1,959,725.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	310,796.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,188,938.80	1,239,886.90
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	309,932.80	346.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	879,006.00	1,239,540.40

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөг)

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,051,899.20	3,051,899.20
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,051,899.20	3,051,899.20
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	18,156.00	18,156.00
9	Тайлант үеийн үр дүн	879,006.00	879,006.00
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,949,061.20	3,949,061.20
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,949,061.20	3,949,061.20
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	134,786.20	134,786.20
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,083,847.40	4,083,847.40
19	Тайлант үеийн үр дүн	1,239,540.40	1,239,540.40
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,323,387.80	5,323,387.80

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөг)

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,331,400.10	4,353,329.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	445,595.20	724,424.20
110	Орлогын албан татвар	288,527.20	553,120.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	288,527.20	553,120.20
113	Хөрөнгийн албан татвар	82,936.40	93,924.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	74,131.70	77,379.70
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	11,747.80	15,214.80
1181	Газрын төлбөр	15,170.50	12,412.10
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	47,213.30	49,752.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,097.20	173,914.60
120	Нийтлэг татварын бус орлого	73,097.20	173,914.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,812,707.70	3,454,990.60
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,749,271.90	3,631,538.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,749,271.90	3,631,538.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,261,909.40	1,673,747.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	484,168.80	734,422.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,063.30	91,675.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,944.00	521,615.80
2104	Хангамж, бараа материалын зардал	35,715.40	40,617.80
2105	Нормативт зардал	900	900
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,000.00	63,013.30
2107	Томилолт, зочны зардал	5,954.50	22,884.40

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,329.40	10,392.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	574,834.00	188,225.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,487,362.50	1,957,790.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	582,128.20	721,791.20
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	366,160.00	351,334.10
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	366,160.00	351,334.10
2200	Дотоод эх үүсвэрээр	366,160.00	351,334.10
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(366,160.00)	(351,334.10)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(157,307.50)	(2,250.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	157,307.50	2,250.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	58,660.80	368,207.10
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	322,771.50	381,432.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	381,432.20	749,639.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөг)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт (хувиар)
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,465,290.40	2,006,008.54	459,281.86	81.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,747,507.80	1,653,924.43	93,583.37	94.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,682,102.40	1,588,519.08	93,583.32	94.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	767,652.40	734,422.88	33,229.52	95.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,956.60	91,675.80	4,280.80	95.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	551,781.10	521,615.75	30,165.35	94.53
2104	Хангамж, бараа материалын зардал	34,418.00	34,417.79	0.21	100.00
2105	Нормативт зардал	900.00	900.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	67,200.00	64,513.33	2,686.67	96.00
2107	Томилолт, зочны зардал	24,300.00	22,884.40	1,415.60	94.17
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,760.00	10,392.42	367.58	96.58
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	129,134.30	107,696.70	21,437.60	83.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,405.40	65,405.34	0.06	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	65,405.40	65,405.34	0.06	100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	599,265.40	349,834.11	249,431.29	58.38
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	118,517.20	2,250.00	116,267.20	1.90
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,465,290.40	2,255,091.65	210,198.75	91.47
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,214,150.30	2,087,619.07	126,531.23	94.29
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	251,140.10	167,472.58	83,667.52	66.68

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	56.00	56.00	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27.00	27.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27.00	27.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөг)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	90,489.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	90,489.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	86,728.6
2104	Хангамж, бараа материалын зардал	6,200.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,528.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,760.5
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,760.5
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	90,489.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	90,489.1

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 6 төсвийн захирагч, орон нутгийн төсвийн орлогын дансыг хамруулахаас сумын ЗДТГ-т хязгаарлалттай дүгнэлт гаргаж, 5 байгууллагыг аудитын түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 511.5 сая төгрөгийн 21 алдаа, зөрчил илэрснээс, 51.6 сая төгрөгийн 8 алдааг залруулж, 8.7 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 14.8 сая төгрөгийн 3 албан шаардлага, 436.4 сая төгрөгийн 8 зөвлөмж өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар нийт 85.3 сая төгрөгийн 6 алдаа¹ зөрчил илэрснээс аудитын явцад 15.7 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 3.1 сая төгрөгийн албан шаардлага, 66.6 сая төгрөгийн 3 зөвлөмж өгч ажиллалаа.

Өмнөх аудитаар өгөгдсөн талбай тусгаарлалтын орлогыг дутуу төвлөрүүлсэнд тогтоогдсон 5.2 сая төгрөгийн төлбөрийн актыг Хутаг-Өндөр сумын Сум дундын Ойн ангийн дансанд шилжүүлж, ЖДҮДС-ийн зээлийн эргэн төлөлтийг орлогоор хүлээн зөвшөөрсөнд залруулж хийж ажиллалаа.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

3.2 Албан шаардлага

1. Байгаль хамгаалах сангийн зарцуулалтад горим сорил хэрэгжүүлэхэд тээвэр шатахууны зардлыг анхан шатны баримтын бүрдэл дутуу, шаардах хуудас, зарлагын баримт байхгүй, хяналт шалгалт хийсэн гэх боловч хяналт шалгалтын төлөвлөгөө, удирдамж, хийсэн ажлын тайлан байхгүй, жолоочийн тооцоо бодоогүй, гарын үсэг байхгүй зориулалт бусаар 3.0 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэхь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, Төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.5 дахь заалтыг үндэслэн зөрчлийг таслан зогсоох, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага тогтоолоо.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Байгаль хамгаалах сангийн журамд нийцээгүй талбай тусгаарлалтын орлого, үнэт цаасны орлого, модны нөхөн төлбөр зэрэг 27.1 сая төгрөгийн орлогыг бүртгэж, тайлагнаж, зарцуулсан нь Засгийн газрын 2022 оны 02

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

дугаар тогтоол, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолыг мөрдөж ажиллах.

1.2 Илрүүлэлт: Ойн нөөц ашигласны төлбөр орлогыг бүрдүүлэхдээ нөхөрлөл, аж ахуй нэгжүүдийн хийлгэсэн талбай тусгаарлалтын гэрээнд заасан хэмжээнээс 3.1 сая төгрөгийг хэтрүүлэн, мод бэлтгэх эрх олгосон нь ойн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэхдээ үндэслэх эрх зүйн актыг баримтлан гэрээний үүргийг хэрэгжүүлэн ажиллах.

1.3 Илрүүлэлт: Сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данснаас өвс тэжээлийн орлогыг шийдвэргүйгээр авч, орлогод бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр тушаалаар батлагдсан НБББББ, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тусгай сангийн хөрөнгийг хууль, журам, эрх зүйн актыг баримтлан орлогыг хүлээн зөвшөөрч, зарцуулалтыг хийж хэвших.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ	3	24.7			3	24.7	3	24.7				
ЗДТГ	2	25.6			2	25.6	2	25.6				
ХХСан	2	1.3			2	1.3	2	1.3				
ОНХСан	1	-			1	-	1	-				
БХСан												
ЖДҮДСан												
ТТЗ	2	15.7			2	15.7	2	15.7				
Дүн	10	67.3			10	67.3	10	67.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ИТХ	2	4.0			1	0.4	1	3.6				
ЗДТГ	6	101.5	2	8.7	2	14.4	2	78.4				
ХХСан	2	15.6					2	15.6				
ОНХСан	3	338.8					3	338.8				
БХСан	2	30.2			1	3.1	1	27.1				
ЖДҮДСан	1	36.3					1	36.3				
ТТЗ	1	3.1					1	3.1				
Дүн	17	529.5	2	8.7	4	17.9	11	502.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ИТХ	-	-						
ЗДТГ	1	321.5				1	321.5	
ОНХС								
ТТЗ	1	-						1 -
Дүн	2	321.5				1	321.5	1 -



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АЛБАН
ШААРДЛАГА

2025 оны 03 дугаар сарын 24

Дугаар 01/154

Булган сум

А0670 253 АНА-2025/017/НА-МА-ТБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Булган аймгийн Баян-Агт сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгаль хамгаалах сангийн зарцуулалтад горим сорил хэрэгжүүлэхэд тээвэр шатахууны зардлыг анхан шатны баримтын бүрдэл дутуу, шаардах хуудас, зарлагын баримт байхгүй, хяналт шалгалт хийсэн гэх боловч хяналт шалгалтын төлөвлөгөө, удирдамж, хийсэн ажлын тайлан байхгүй, жолоочийн тооцоо бодоогүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 3,069,400.00 (гурван сая жаран есөн мянга дөрвөн зуу) төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.3-д "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ", 14.4-д "нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" дэхь заалтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-т "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэсэн заалтыг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

032504548

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баян-Агт сумын Засаг дарга (Б.Бямбажав), санхүү албаны дарга (С.Эрдэнэчимэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТОР

Г.ЦЭРЭНЛХАМ

